

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Бат-Эрдэнэ	Дугаар	L360
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Сайхан- Овоо сум
Төрсөн газар	Сайхан- Овоо сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Гүндүүжамбаалин хийдийн тэргүүн лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хутагт ламын хийд, Барь ламын хийд	Сүм хийдийн дугаар	ДУСО 014, ДУСО 016
Одоогийн сүм хийд	Гүндүүжамбаалин хийд	Сүм хийдийн дугаар	ДУСО 015
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны6-р сарын 30	Ярилцлага авсан хүн	Жужа



Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Хутагт ламын хийд, Барь ламын хийд, Гүндүүжамбаалин хийд

Жужа: Та энэ Гүндүүжамбаалин хийдийг сэргээж болсныг ярина уу?
 Бат-Эрдэнэ: За 1990 оны намар энэ хийдийг сэргээж гэж хуучин шавилж байсан Даваа, Цэрэнчимэд, Содном , Хоёр Цэрэнчимэд хоёр Содном байсан. Мөн Жийжаа, Дугар, Ванган гэх лам хуваргууд мөн хуучин намын дарга байсан Найдан нарын хүмүүс ярилцаад ерэн оны намар анхны хурлаа хурж эхэлсэн.
 Жужа: Энэ лам нар тухайн үедээ хэдэн настай хүмүүс байсан бэ?
 Бат-Эрдэнэ: Дунджаар 70-80 настай хүмүүс байсан.
 Жужа: Тэд бүгд үрд өмнө энэ хийдэд сууж байсан уу?
 Бат-Эрдэнэ: Тийм, сууж байсан гэдэг. Тухайн үедээ хийд орноо хаахаас өмнө тэд хамгийн бага нь долоон настай, ахмад нь хорин таван настай байцгаасан гэж ярьдаг байсан.
 Жужа: Эдгээр лам нар одоо амьд байна уу?
 Бат-Эрдэнэ: Бараг бүгдээрээ шахуу бурхан болцгоосон.
 Жужа: Ерээнд олд яг хуучны хэд орчим лам байсан юм бэ?

Энэхүү нар дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Бат-Эрдэнэ: За ер нь энэ хоёр хийд бол нэгдмэл нэг зохион байгуулалттай байсан. Тэр урдаа Барь ламын хийд нь 17 дуган дацантай, гол сургалтууд нь тэндээ явагддаг байсан бол чог хурлууд нь дандаа хойноо явадаг байж. Хутагт лам , Барь ламыг бүр хүүхэд байхад нь таньж мэдээд энэ сайн лам болно гэж өөрийн ивээлдээ авсан гэдэг. Тэгээд Барь лам Төвдөд 16 жил явж дөчин насандаа эргэж ирсэн. Тэгээд ирэхэд нь Хутагт лам одоо манай энэ хамгийн баруунтаа байгаа Найдангийн дуганыг барилуулж өгсөн гэдэг. Хутагт ламын хийд 11 дугантай, тав зургаан жастай байсан. Дөрвөн дацантай, мамба дацан, дүйнхор, жүдийн дацан, чойрын дацан энэ дөрөв байсан. Хутагт ламын хийд Зүүн хүрээтэй их холбоотой байсан. Гавжийн дамжаа, аграмбын дамжаа барьдг байсан. Хоёр хийд нийлээд 500 орчим ламтай байсан. Хошуу хурал чинь мянган ламын данстай байсан гэдэг. Хутагт ламын хийд дээр цам гарна. Майдрьг хоёр хийд хоёулаа эргэнэ. Урд хийдэд зуны эхэн сарын арван зургаанд майдар эргэнэ. Хойд хийдэд намын эхэн сарын хорин хоёронд эргэдэг байсан. Манайх чинь бас зуны эхэн сарын 11-16 хүртэл чагын хурал тав гэж тав хоног хурна. Урд хойд хоёр хийд хоёулаа хурдаг байсан юм гэнэ лээ.
 Жужа: Хайлан хурдаг байсан уу?
 Бат-Эрдэнэ: Хайлангаа нэгдэж хурдаг байсан.
 Жужа: Ямар ямар дуганууд байсан бэ?
 Бат-Эрдэнэ: Цогчин дуган, одоо буурин дэр нь нэг гэр дуган байгаа. Баруун сахиусны дуган буюу Гомбо сахиусны дуган, Дэмчигийн дуган, Аюушийн дуган, Майдрын дуган, Жанрайсийн дуган, найдангийн дуган за тэгээд зүүн сахиус буюу Лхамын дуган, Барь эхийн дуган хоёр нэг байсан. Дөөд дувийн дуган, Сандуйн дуган, Дорж дүв, за баруун гүдэм буюу Барь ламын өөрийн дуган. Зүүн гүдэм буюу цорж ламын дуган, Бид Найдан багш гэж ярьдаг байсан. Бас зүүгийн дуган гэж байсан. За мөн ламиран дацан гэж шинээр байгуулж байсан юм гэнэ лээ. Ламиран дацан гэж байсан юм гэнэ лээ. Үндсэндээ таван дацантай болох байсан юм байна.
 Жужа: Хэр олон суваргатай байсан юм бол?
 Бат-Эрдэнэ: Өө олон байсан байх. Би сайн мэдэхгүй. Хамгийн том нь энэ хойд гэрэлт цагаан суварга гэж ярьдаг. Хөтлийн цагаан суварга. Манай энэ хойд хийдийг чинь анхны тэр найдан дуганыг Хутагт лам шавьдаа Барь ламд барьж өгсөн, үүнээс хойш Барь лам энэ орон хийдийг өргөжүүлэн дэлгэрүүлсэн юм гэнэ лээ. Барь лам Төвдөд 16 жил суугаад нутаг буцахын өмнө багшаасаа би орон нутагтаа очоод нэг оромж байгуулмаар байна. Та газар нутаг зааж өгөвч гэсэнд тэр багш нь өө танай тэнд үлдсэн багш чинь чамд газар орон сүм хийд бэлтгэж байна гэсэн юм гэдэг. Энэ нь тэгээд энэ хийдийг хэлсэн гэж ярилцдаг.
 Жужа: Энэ хийдийн хамгийн сүүлийн хамба нь хэн байсан бэ?
 Бат-эрдэнэ: Барь ламын дараа Минжүүр Ёнзон гэж хүн байсан. 1937 оны өвөл баригдаж яваад хороогдсон юм гэнэ лээ. Одоо тэр Даваа ламын багш нь бөгөөд тэдний хамаатан болох хүн. Тэр Ёнзон багшийн ном судар, сүмбэ бурхан тахил нь үндсэндээ тэр өвгөнд уламжлагдан хадгалагдаж байгаа.
 Бат-Эрдэнэ: Барь ламын дүрийн тухайд хувьсгалаас өмнө гурван дүр тодорсон. Дөрөв дэх дүр нь бүр хожуу 1970-аад оныг хүртэл Эрдэнэдалай суманд арав гаруй настай хүү байж байгаад тавал болсон. Хутагт ламын

Энэхүү нар дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Бат-Эрдэнэ: Хориод лам байсан юм болов уу, би яг нарийн мэдэхгүй юм. Би тэр үед сургуульд байсан. Амралтаараа ирэхэд дүйчэн өдрүүдийн уншлага хуралд хөдөө гадаа энэ тэндээс зэргэлдээ сумдаас энэ хийдэд сууж байсан гээд настай лам нар цуглахад хорь орчим хүн болдог байсан.
 Жужа: Тэр үед хамба нь хэн байсан бэ?
 Бат-Эрдэнэ: Данаа гэж хүн байсан. 2004 он хүртэл ажилласан. Тэгээд арга буюу өндөр наслаад надад хүлээлгэж өгсөн.
 Жужа: Одоо танай хийд хэдэн ламтай вэ?
 Бат-Эрдэнэ: 14-15 тооны ламтай. Ихэнх нь хүүхдүүд.
 Жужа: За ямар хурлууд хурж байна, тогтмол хурал хурж байна уу?
 Бат-Эрдэнэ: Нодингоос эхлээд өвөл зунгүй, өдөр бүхэн цогчин хурж байна. Түүнээс өмнө зөвхөн зундаа цогчин тасралтгүй хурж өвлөөр дүйчэн өдрүүдэд л хурал хурж байсан.
 Жужа: Сарын ямар ямар хурлууд хурж байна.
 Бат-Эрдэнэ: Шинийн найман арван таванд Дарь эхийн мандал, хорин есөнд арван хангал.
 Жужа: Ямар шүтээнтэй вэ?
 Бат-Эрдэнэ: Манай хойд хийдийн шүтээн бол Гомбо, Лхам хоёр. Урд Хутагт ламын хийдийн шүтээн бол Улаан Жамсран. Хошуу хурлынх Чойжоо.
 Жужа: Шинэ дуган хэдэн онд баригдсан бэ?
 Бат-Эрдэнэ: 2004 онд баригдсан. Суваргыг 2000 онд манай хийдээс хэлмэгдсэн лам нарын дурсгалыг мөнхжүүлэх зорилгоор тэдний үр хүүхэд ач гуч нар нөхөн олговрынхоо мөнгийг нийлүүлж сумын ИТХ-ын дарга Ц. Мөнхбаяр зохион байгуулж босгосон юм. Манай энэ хоёр хийдээс чинь зугаадам лам хэлмэгдсэн гэдэг, Бүх нэр ус нь суварган дээр бичээстэй байгаа.
 Жужа: Энэ хойд талын гэр ямар учиртай вэ?
 Бат-Эрдэнэ: Энэ гэр барьсан буурь манай хийдийн бурхан шүтээн агүүлж байсан дуганы туурь юм гэнэ лээ. Одоо энэ гэрт энэ хоёр хийдтэй холбоотой тийм музей маягийн юм байгуулсан юм.
 Жужа: Уг хоёр хийдээс өвлөж хадгалж үлдээсэн бурхан шүтээн , судар ном танай хийдэд бий юу?
 Бат-Эрдэнэ: Уг хоёр хийдээс дамжиж ирсэн цөөн зүйлс дугдан ч бий, тэр музейд ч бий. Судар ном барууд голчлон.
 Жужа: Таних өөр бусад хийдтэй ямар холбоотой байна?
 Бат-Эрдэнэ: Хотын хийдүүдтэй нэг их холбоогүй. Харин хөрш сум орны хийдүүдтэй хамтарч хурдаг.
 Жужа: Танай лам нарын дотор гэлэн гэцэл сахилтай лам нар бий юу?
 Бат-Эрдэнэ: Нэг их байхгүй. Манай Даваа гуай л гэлэн сахилтай.
 Жужа: Өөр өндөр настай лам нар байна уу?
 Бат-Эрдэнэ: Даваа гуайгаас гадна Дугар гэж өвгөн сумын төв дээр бий. Энэ жил 86 хүрч байгаа.
 Жужа: За эдгээр хоёр хийдийн түүхээс өөр мэдээлэл байна уу?

Энэхүү нар дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

тухайд таван дүр тодорч хамгийн сүүлчийн дүр нь Тайж хүний хүүхэд байж байгаад 1931, 1932 оны үед нөгөө Тайж язгууртны эсрэг нам төрийн арга хэмжээ авч эхлэхэд баригдаж яваад суллагдаж ирж, тэгээд 1937онд өөрөө гэнэт алга болчихсон юм гэнэ лээ, энд байж байгаад. Тэгээд сүүлд нь бол хотод амьдарч байсан мэдээ байдаг.
 Жужа: Энэ хоёр хийд хэдэн онд хаагдаж нураагдсан бэ?
 Бат-Эрдэнэ: 1937 онд, тэгээд гучин долоон оноос эхлэн мал ахуй эд хөрөнгийг нь тарааж сүм хийдийг нь нурааж, сүм бригад руу зөвж эхэлсэн.
 Жужа: Энэ зоч лам нар байсан уу?
 Бат-Эрдэнэ: Байсан гэнэ лээ. Энэ хойд хийдийн хойно байх цагаан овооны энгэр дээр Тантан чиглэлийн зоч лам нар. Урд хийдийн өмнө талд Ханд чиглэлийн зоч нар Ванчин цорж гэдэг багштай байсан юм гэдэг. Ийм хоёр төрлийн зочтой байсан юм гэнэ лээ. Ванчин цорж гэж мундаг хүн байсан юм гэж ярьдаг. Энэ хойд хийдийнх нь болохоор Тантангийн чиглэлийн багш нь Чоймбол гэж хүн байсан юм гэнэ лээ.
 Жужа: Энэ цам нь ямар цам гардаг байсан бол?
 Бат-Эрдэнэ: Зуу гаруй цам гурван өдөр л гардаг байсан юм гэнэ лээ. Тэр Хутагт амын хоёрдугаар дүр л анх зүүн хүрэнээс залж цамынхаа дэг жаягийг зохиосон юм гэдэг.
 Жужа: Хийдийн ойролцоо борчууд хэр амьдарч байсан юм бол?
 Бат-Эрдэнэ: Бог голдуу цөөн малтай борчууд олон байдаг. Тэдний өрх гэрүүд цөм энэ горооны гадуур байдаг байсан гэнэ лээ.

Энэхүү нар дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон